

ЗӨВЛӨХ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ТУХАЙ ЗАРЛАЛ

2023 оны 12 дугаар сарын 25

Улаанбаатар хот

1. Нийслэлийн Худалдан авах ажиллагааны газар нь НХААГ/202311384 дугаартай “Улаанбаатар хотын хөгжлийн ерөнхий төлөвлөгөө”-г боловсруулах зөвлөх үйлчилгээний ажлын зөвлөхийн үйлчилгээ үзүүлэх хүсэлтэй этгээдийг мэдүүлгээ ирүүлэхийг урьж байна. Үүнд:

2. Мэдүүлгээ ирүүлж буй зөвлөх нь уг үйлчилгээг гүйцэтгэх чадвартайг нотлох дараах мэдээллийг ирүүлнэ.

2.1. Улсын бүртгэлийн гэрчилгээг “Төрийн худалдан авах ажиллагааны цахим систем” www.tender.gov.mn болон “Төрийн мэдээлэл солилцооны ХУР систем”-ээр дамжуулан шалгана. */Хэрэв гадаадын хуулийн этгээд тендер ирүүлэх тохиолдолд үүсгэн байгуулагдсан улсын эрх бүхий байгууллагаас гаргасан дээрх баримт бичгийг консулын баталгаа гаргуулан өөрийн тендерт хавсарган ирүүлнэ./*

2.2. Барилга, хот байгуулалтын яамнаас олгодог:

- ЗТ-9.1 – Хот, тосгоны ерөнхий төлөвлөгөө, хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөө, хот төлөвлөлтийн суурь судалгаа эсхүл
- Х.Б-1.1- Хот, тосгоны хөгжлийн ерөнхий төлөвлөгөө, хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөө, чөлөөт бүсийн хөгжлийн ерөнхий төлөвлөгөө, хот тосгоныг хөгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө

/Гадаадын хуулийн этгээдийн хувьд эрх бүхий байгууллагаас олгосон энэ заалтад заасан тусгай зөвшөөрлүүдтэй дүйцэхүйц тусгай зөвшөөрлийг консулын баталгаа гаргуулан өөрийн тендерт хавсарган ирүүлнэ./

2.3. Монгол Улсын, эсхүл үүсгэн байгуулагдсан улсын хуулийн дагуу татвар, хураамж, төлбөрөө тухайн тендер нээсэн өдрийн байдлаар бүрэн төлсөн байна. Нийгмийн даатгал, татварын тодорхойлолтыг ирүүлэх шаардлагагүй, “Төрийн худалдан авах ажиллагааны цахим систем” www.tender.gov.mn болон “Төрийн мэдээлэл солилцооны ХУР систем”-ээр дамжуулан Татварын ерөнхий газар, Нийгмийн даатгалын ерөнхий газрын цахим мэдээллийн сангаас шалгана. */Хэрэв гадаадын хуулийн этгээд тендер ирүүлэх тохиолдолд үүсгэн байгуулагдсан улсын эрх бүхий байгууллагаас гаргасан тухайн улсын хууль тогтоомжийн дагуу татвар, хураамж, төлбөрөө төлсөн болохыг нотлох баримт бичгийг консулын баталгаа гаргуулан өөрийн тендерт хавсарган ирүүлнэ./*

2.4. Дараах тодорхойлолтуудыг тендер зарлагдсан өдрөөс хойш авсан байх ба тендер нээсэн өдрийн байдлаар хүчин төгөлдөр байна. Үүнд:

-Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газрын тодорхойлолт ирүүлнэ.

Анхааруулга: Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газрын тодорхойлолт авах хүсэлтийг тендер оролцогч Худалдан авах ажиллагааны цахим систем (www.tender.gov.mn)-д тоон гарын үсэг ашиглан тендерийн нээлтээс өмнө хүчин төгөлдөр тодорхойлолтыг цахим хэлбэрээр ирүүлнэ.

-Шүүхийн ерөнхий зөвлөлийн Шүүхийн тусгай архивын тодорхойлолт ирүүлнэ.

Анхааруулга: Тендерийн нээлт хийхээс 3-аас доошгүй хоногийн өмнө нэвтрэн орж шүүхийн тусгай архивын лавлагаа авах хүсэлтийг илгээх бөгөөд Шүүхийн ерөнхий зөвлөл хянан үзэж лавлагаа цахимаар илгээдэг болохыг анхаарна уу.

/Хэрэв гадаадын хуулийн этгээд тендер ирүүлэх тохиолдолд үүсгэн байгуулагдсан улсын эрх бүхий байгууллагаас гаргасан дээрх баримт бичгийг консулын баталгаа гаргуулан өөрийн тендерт хавсарган ирүүлнэ./

2.5. Байгууллагын дэлгэрэнгүй танилцуулгыг ирүүлнэ.

2.6. Сүүлийн 3 жил (2020, 2021, 2022 он)-ийн дундаж борлуулалтын орлогын хэмжээ нь батлагдсан төсөвт өртгийн үнийн дүнгийн 60 хувиас багагүй байна.

2.7. Сүүлийн 3 жил (2020, 2021, 2022 он)-д хийж гүйцэтгэсэн ажлын жагсаалтыг хүснэгтээр ирүүлнэ. Сүүлийн 3 жил буюу 2020, 2021, 2022 онуудын аль нэг жилд батлагдсан төсөвт өртгийн үнийн дүнгийн 50 хувиас багагүй үнийн дүнтэй ижил төстэй ажлын үндсэн гүйцэтгэгчээр хоёроос доошгүй удаа ажилласан байх ба

гүйцэтгэсэн хоёр ажлын гэрээ, акт, захиалагчийн тодорхойлолтыг хавсаргана. Ижил төстэй ажилд Хот, байгуулалтын баримт бичиг, Хот төлөвлөлтийн суурь судалгааг хийж гүйцэтгэсэнд тооцно.

/Хэрэв гадаадын хуулийн этгээд тендер ирүүлэх тохиолдолд үүсгэн байгуулагдсан улсын эрх бүхий байгууллагаас гаргасан дээрх баримт бичгийг консулын баталгаа гаргуулан өөрийн тендерт хавсарган ирүүлнэ./

2.8. Голлох болон инженер техникийн ажилтнуудын дэлгэрэнгүй мэдээллийг жагсаалтаар ирүүлнэ. */Хэрэв гадаадын хуулийн этгээд тендер ирүүлэх тохиолдолд ажиллах хүчний жагсаалтыг ирүүлэхдээ дипломын хуулбарыг консулын баталгаа гаргуулан өөрийн тендерт хавсарган ирүүлнэ./*

3. Чадварыг нэмэгдүүлж сайжруулах зорилгоор зөвлөхүүд түншлэлийн хэлбэрээр оролцож болно. Түншлэл нь энэ зарлалын 2.6, 2.7-д заасан шаардлагыг түншлэлийн гишүүдийн тооноос үл хамааран төлөөлөх эрх бүхий гишүүн дээрх шалгуур үзүүлэлтийн 100 хувь, түншлэлийн гишүүн 40 хүртлэх хувь, туслан гүйцэтгэгч 25 хүртэлх хувийг тус тус хангасан байна.

4. Мэдүүлгийг Монгол хэл дээр ирүүлнэ. Гадаадын хэл дээрх бүх баримт бичгийг Монгол хэл дээр орчуулж ирүүлнэ.

Сонирхсон этгээд нэмэлт мэдээллийг 2024 оны 01 дүгээр сарын 08-ны өдрийн 09:00 цаг хүртэл авч болох бөгөөд мэдүүлгээ Төрийн худалдан авах ажиллагааны цахим систем www.tender.gov.mn-ээр 2024 оны 01 дүгээр сарын 08-ны өдрийн 09:35 цагийн дотор ирүүлнэ ҮҮ.

Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, 4 дүгээр хороо, Бага тойруу-15,
Нийслэлийн Засаг захиргааны IV байр, 10 дугаар давхар,
Нийслэлийн Худалдан авах ажиллагааны газар, Утас: 75757807
Цахим хаяг: www.tender.gov.mn, www.ub-procurement.mn

ЗӨВШӨӨРСӨН:

ГАЗРЫН ДАРГЫН АЛБАН ҮҮРГИЙГ

ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ

Д.БАТЦЭЦЭГ

ANNOUNCEMENT OF CONSULTING SERVICES

Date: **December 25, 2023**
city

Ulaanbaatar

The Procurement Agency of Capital City is seeking an application for a consulting service for the **General development plan of Ulaanbaatar city**. Therefore, those who wish to provide consulting services are invited to submit an application.

1. This consulting service number is **НХААГ/202311384**.

2. The applicant consultant should provide the following information to prove their ability to fulfil the service.

2.1 A copy of the original state registration certificate shall be submitted. The state registration certificate will be checked through the "State Procurement Electronic System" www.tender.gov.mn and the "State Information Exchange HUR System".

/If a foreign legal entity submits a tender, the above documents issued by the competent authority of the country of incorporation must be attached to its tender with a consular guarantee./

2.2 Ministry of Construction and Urban development provides:

1. ZT-9.1 - City and village general plan, partial general plan, basic research of urban planning
2. KH.B-1.1 - City and village development master plan, partial master plan, free zone development master plan, town and village development action plan

/For a foreign legal entity, a special permit equivalent to the special permits specified in this clause issued by the competent authority must be attached to its bid with a consular guarantee./

2.3 In accordance with the laws of Mongolia or the country of establishment, taxes, fees and fees have been paid in full as of the date of bid opening. It is not necessary to submit social insurance and tax declarations, it is checked in the electronic database of the General Tax Department and the General Department of Social Insurance through the "State Procurement Electronic System" www.tender.gov.mn and the "State Information Exchange HUR System".

/If a foreign legal entity submits a tender, documents proving that taxes, fees and fees have been paid in accordance with the laws of the country issued by the competent authority of the country of establishment must be attached to the tender with a consular guarantee./

2.4 The following definitions must be obtained from the date of bidding and are valid from the date of bid opening. Those definitions shall include:

-Submit a description of the court's execution office.

Warning: Bidders must submit a valid identification to the Electronic Procurement System (www.tender.gov.mn) before the opening of the tender using their national digital signature.

-The court's special archive reference from the General Council of the court.

Warning: Please note that at least 3 days before the bid opening, a request for a special archive of the court will be sent and the inquiry will be sent electronically after review by the General Council of the Court.

/If a foreign legal entity submits a tender, the above-mentioned document issued by the competent authority of the country of establishment shall be attached to its tender with a consular guarantee./

2.5 Submit a detailed introduction of the organization.

2.6 Sales revenue for any of the last 3 years (2020, 2021 and 2022) shall not be less than 60% of the budgeted cost.

2.7 The list of works completed in any of the last 3 years (2020, 2021 and 2022) is tabulated and similar work worth at least 50% of the budgeted cost has been done at least twice. Evidence should be attached to the contract, act and customer's reference. For similar work, it will be considered that the City and Development Documents and the Basic Research of City Planning have been completed.

/If a foreign legal entity submits a tender, the above-mentioned document issued by the competent authority of the country of establishment shall be attached to its tender with a consular guarantee./

2.8 Detailed information from key engineers and technicians will be provided.

/If a foreign legal entity submits a tender, the above-mentioned document issued by the competent authority of the country of establishment shall be attached to its tender with a consular guarantee./

2.9 Detailed information from key engineers and technicians will be provided.

3. Consultants may participate in partnership to enhance skills. The partnership meets the requirements set forth in Sections 2.6 and 2.7 of the above criteria. Regardless of the number of members of the partnership, representative member meet requirements for 100 percent of the above criteria, up to 40 percent of the partnership members, and up to 25 percent of the subcontractors, respectively.

4. The statement must be submitted in Mongolian. All foreign language documents must be translated into Mongolian.

Interested eligible participants may obtain additional clarifications and information related to consulting service until **09:00 on January 08, 2024** and submit their applications via Public Procurement electronic system www.tender.gov.mn on **January 08, 2024 at 09:35**.

The Procurement agency of the Capital City,
10th floor, Capital governing office building No4, Bagatoiruu-15,
4th sub district, Chingeltei district, Ulaanbaatar, Mongolia
Cell: 75757810
Website: www.tender.gov.mn, www.ub-procurement.mn

APPROVED BY:
ACTING CHIEF OF PROCUREMENT AGENCY
OF CAPITAL CITY

BATTSETSEG.D